

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2025/97-ШТА-НА

Чойбалсан хот 2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuayags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
Ерөнхий мэдээлэл.....	5
БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА.....	6
А.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна.....	6
А.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.....	7
БҮЛЭГ Б. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СЕХ-НООС ХУВААРИЛСАН ЗАРДЛЫГ ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ ХООРОНД ГҮЙЛГЭН ЗАРЦУУЛСАН, МӨН СУРГАЛТЫН ЗАРДЛААС ХУВЬ ХҮНИЙ ДАНС РУУ ШИЛЖҮҮЛЭГ ХИЙСЭН БАЙНА	7
Б.1 Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн сургалтын зардлаас хувь хүний данс руу шилжүүлэг хийсэн байна.....	7
Б.2. Хөлөнбуйр сум нь аймгийн Сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийг бүрэн зарцуулсан бол Баяндун сум нь хуваарилсан төсвийн 99.6 хувийг зарцуулсан байна	8
БҮЛЭГ В. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ ХООРОНД 60.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ЗӨРҮҮТЭЙ ТАЙЛАГНАСАН БАЙНА.....	9
В.1 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилал хооронд 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.....	9
В.2 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	10
 ДҮГНЭЛТ:	 10
САНАЛ:	10
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	11-12
АЛБАН ШААРДЛАГА:.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагналын аудит
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Батлагдсан төсөв, хуваарилагдаж ирсэн төсөв.	6
Хүснэгт 2	Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.	7
Хүснэгт 3	Аймгийн Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.	7-8
Хүснэгт 4	Сумын Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл	9

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 ¹ -д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2025 оны А/44 дүгээр тушаал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д “Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана” гэж заасныг үндэслэн гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргахад зорилт чиглэгдлээ. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</i> • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;</i> • <i>Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс эхлүүлж, тайланг УАГ-ын Нийцлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлээ.

¹ шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 22/03 дугаар тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Хөлөнбуйр сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05/01 дүгээр тогтоолоор сумын 2025 оны нөхөн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан. Мөн Баяндун сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын сонгуулийн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дорнод аймгийн сонгуулийн хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр захирамжаар аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогчоор Цэрэндоржийн Амгаланзаяаг, 2025 он 06 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар захирамжаар аймгийн Сонгуулийн хорооны бичиг хэргийн ажилтнаар Өлзийтөмөрийн Цэвэлмааг тус тус томилсон байна.

Монгол улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулиар ажиллах мэдээллийн технологийн багийн бүрэлдэхүүнийг Дорнод аймагт 4 хүнтэй ажиллахаар баталсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 11, сумдын сонгуулийн хороодод 10, хэсгийн хороодод 23, мэдээлэл технологийн багт болон даамлаар 9, нийт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 53 албан хаагчид аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Дорнод аймгийн Сонгуулийн хороонд 74.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Зөөврийн хайрцгаар 11 хүн санал өгөх хүсэлт гаргаснаас 2025.06.21-ний өдөр 11 хүн саналаа өгсөн.

Тус нөхөн сонгууль болсон сумдын санал хураалтад Баяндун сумын 1-р хэсэгт 858 сонгогч саналаа өгөхөөс 283 сонгогч буюу 32.98 хувийн ирцтэй, Баяндун сумын 2-р хэсэг 308 сонгогч саналаа өгөхөөс 127 сонгогч буюу 41.23 хувийн ирцтэй, Хөлөнбуйр сумын 1-р хэсэг 404 сонгогч саналаа өгөхөөс 200 сонгогч буюу 49.5 хувийн ирцтэй тус тус сонгуульд оролцсон байна.

БҮЛЭГ А. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ ОЛГОСОН БАЙНА.

А.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/18 дугаар тушаалаар аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн Дорнод аймгийн сонгуулийн хорооны төсвийг 74.1 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 1. Батлагдсан төсөв, хуваарилагдаж ирсэн төсөв.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Хуваарилагдаж ирсэн төсөв	Зөрүү
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	160.0	160.0	-
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	1,425.0	1,425.0	-
3	Аймаг, сумын хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	1,050.0	1,050.0	-
4	Аймаг, сумын хэсгийн хорооны шуудан холбооны зардал	1,400.0	1,400.0	-
5	Аймаг, сумын хэсгийн хорооны унааны зардал	3,360.0	3,360.0	-
6	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	900.0	900.0	-
7	Сурталчилгааны зардал	2,100.0	2,100.0	-
8	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	1,000.0	1,000.0	-
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах,хүргэх ачаа, томилолтын зардал	9,122.0	9,122.0	-
10	Томилолтын зардал / Саналын хуудас аймагт СЕХ хүргэх зардал	4,176.0	4,176.0	-
11	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	420.0	420.0	-
12	Шуурхай багийн зардал	3,440.0	3,440.0	-
13	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал НДШ	37,900.8	37,900.8	-
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал НДШ	7,627.2	7,627.2	-
	Дүн	74,081.0	74,081.0	

Эх сурвалж: аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв, дансны хуулга.

Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

А.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3-т заасан зардлуудад төсөв хуваарилсан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Хуваарилагдаж ирсэн төсөв	
			Хөлөнбуйр сум	Баяндун сум
1	Аймаг, сумын хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	750.0	300.0	450.0
2	Аймаг, сумын хэсгийн хорооны шуудан холбооны зардал	1,000.0	400.0	600.0
3	Сурталчилгааны зардал	600.0	200.0	400.0
4	Саналын хуудас, төхөөрөмжийн авах,хүргэх ачаа, томилолтын зардал	2,090.0	880.0	1,210.0
5	Томилолтын зардал / Саналын хуудас аймагт СЕХ хүргэх зардал	660.0	100.0	560.0
6	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	420.0	140.0	280.0
7	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал НДШ	27,151.6	9,934.4	17,217.2
8	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал НДШ	4,046.0	1,618.4	2,427.6
	Дүн	36,717.6	13,572.8	23,144.8

Эх сурвалж: аймаг, сумын Сонгуулийн хорооны төсвийн хуваарь.

Аудитаар аймаг, сумын төсвийн хуваарилалтыг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу давтан тооцож үзэхэд зөрүү гараагүй.

БҮЛЭГ Б. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СЕХ-НООС ХУВААРИЛСАН ЗАРДЛЫГ ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ ХООРОНД ГҮЙЛГЭН ЗАРЦУУЛСАН, МӨН СУРГАЛТЫН ЗАРДЛААС ХУВЬ ХҮНИЙ ДАНС РУУ ШИЛЖҮҮЛЭГ ХИЙСЭН БАЙНА.

Б.1 Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн сургалтын зардлаас хувь хүний данс руу шилжүүлэг хийсэн байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2025 оны 1/177, 3/230 дугаар албан бичгээр ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарт заасны дагуу аймаг, нийслэл, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 3. Аймгийн Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	160.0	160.0	-
2	Сонгуулийн байгууллагын ажилтан, сургалтын зардал	1,425.0	1,425.0	-
3	Аймаг, сумын хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	300.0	300.0	-
4	Аймаг, сумын хэсгийн хорооны шуудан холбооны зардал	400.0	1,340.0	60.0
5	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	1,000.0		

6	Аймаг, сумын хэсгийн хорооны унааны зардал	3,360.0	3,360.0	-
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	900.0	900.0	-
8	Сурталчилгааны зардал	1,500.0	1,560.0	(60.0)
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах,хүргэх ачаа, томилолтын зардал	7,032.0	10,548.0	-
10	Томилолтын зардал / Саналын хуудас аймагт СЕХ хүргэх зардал	3,516.0		-
11	Шуурхай багийн зардал	3,440.0	3,440.0	-
12	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал НДШ	10,749.2	13,885.2	445.2
13	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал НДШ	3,581.2		
14	Сонгуулийн Ерөнхий Хорооны дансанд буцааж төвлөрүүлсэн		445.2	
Дүн		37,363.4	37,363.4	

Эх сурвалж: аймгийн Сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Аймгийн Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллын хүснэгтээс харахад сурталчилгааны зардалд 1,500.0 мянган төгрөг төлөвлөснөөс 1,560.0 мянган төгрөгийг зарцуулсан, шуудан холбоо, унааны зардлыг 1,400.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,340.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан нь СЕХ-ны даргын 2021 оны 03 сарын 19-ний өдрийн "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" -ын 3.8-д "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сургалтын зардлын хоолны үнэ болох 595.0 мянган төгрөгийг хувь хүний данс руу шилжүүлсэн байна. Энэ нь СЕХ-ны даргын 2021 оны 03 сарын 19-ний өдрийн "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам" -ын 3.7-д "Байгууллага, хувь хүнтэй хийх төлбөр тооцоог анхан шатны баримт болон холбогдох шийдвэрийг үндэслэн бэлэн бусаар буюу дансаар дамжуулан хийнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 36.9 сая төгрөгийг зарцуулж 0.4 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Б.2. Хөлөнбуйр сум нь аймгийн Сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийг бүрэн зарцуулсан бол Баяндун сум нь хуваарилсан төсвийн 99.6 хувийг зарцуулсан байна.

Сумын Сонгуулийн хороод нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 4. сумын Сонгуулийн хорооны төсөв, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Сумын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Баяндун	23,144.8	23,067.2	77.6	99.6
2	Хөлөнбуйр	13,572.8	13,572.8	-	100
дүн		36,717.6	36,640.0	77.6	99.9

Эх сурвалж: сумын Сонгуулийн хороодын төсвийн гүйцэтгэл

Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороо нь цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас худалдан авсан 140.0 мянган төгрөгийн шатахууныг бэлэн байдал хангах зорилгоор цахилгаан үүсгүүрт хийж байршуулсан. Сумын нөхөн сонгууль зохион байгуулагдах хугацаанд цахилгаан тасрах эрсдэл гараагүй тул шатахууныг ашиглаагүй байна.

Бараа материалын тайлангаар тус шатахууныг зарцуулснаар тайлагнасан байна. Энэ нь СЕХ-ны даргын 2021 оны 03 сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6-д "Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул зөрчил арилгуулах **албан шаардлага** өгсөн.

Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан бол, Баяндун сумын Сонгуулийн хороо нь 23,067.2 мянган төгрөгийг зарцуулж 77.6 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны дансанд буцааж төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ В. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ ХООРОНД 60.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ЗӨРҮҮТЭЙ ТАЙЛАГНАСАН БАЙНА.

В.1 Аймгийн сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилал хооронд 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардлын тайлангаа гаргасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайланд батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар зарцуулснаар тайлагнасан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг эдийн засгийн ангиллаар тулган шалгахад сурталчилгааны зардалд 1,500.0 мянган төгрөг төлөвлөснөөс 1,560.0 мянган төгрөгийг зарцуулсан, шуудан холбоо, унааны зардлыг 1,400.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,340.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилал хооронд 60.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

В.2 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/177 дугаар албан бичгээр Дорнод аймгийн Сонгуулийн хороодын дансны жагсаалтыг хүргүүлсэн байна. Сонгуулийн хороодын зардлын гүйлгээнд аймаг, сумын төрийн сангаас хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч Ц.Амгаланзаяа, Хөлөнбуйр сумын сонгуулийн хорооны нягтлан бодогч А.Ганцэцэг, Баяндун сумын сонгуулийн хорооны нягтлан бодогч П.Энхчимэг нар нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасан санхүү, эдийн засгийн бакалавр, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, санхүүгийн тайлан гаргах чадвартай байх гэсэн шалгуурыг хангасан байна.

Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын гүйлгээний баримт дээр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс батлагдсан зардлыг хууль, журмын дагуу хуваарилж олгосон байна.
2. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн сургалтын зардлаас хувь хүний данс руу шилжүүлэг хийсэн байна.
3. Нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилал хооронд 60.0 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт 795.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 140.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 655.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

1. Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос хуваарилсан зардлыг 60.0 мянган төгрөгөөр эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, мөн сургалтын зардлаас 595.0 мянган төгрөгийг хувь хүний данс руу шилжүүлэг хийсэн зөрчлийг нэгтгэсэн тайлангийн материаллаг байдалд авч үзэх.

ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 4/24

Чойрхсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.


3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Дорнод аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Б.Батжаргал)-д даалгасугай



Байгууллагын нэр: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
Газар хэлтэс: Захиргаа
Албан тушаал: Дарга, Тэргүүлэх аудитор
Овог нэр: Баярмагнай Болортуул
Зурсан огноо: 2025.07.07 15:29:42

2125010048



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /мянган төгрөг/
1	Дорнод аймгийн Сонгуулийн хороо	220/A1171311 ДОА-2025/97/ШТА-НА	140.0
Дүн			140.0

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 220/А-117311
ДОА-2025/97-ШТА-НА

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөлөнбуйр сумын Сонгуулийн хороо нь цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас худалдан авсан 140.0 мянган төгрөгийн шатахууныг бэлэн байдал хангах зорилгоор цахилгаан үүсгүүрт байршуулсан. Сумын нөхөн сонгууль зохион байгуулагдах хугацаанд цахилгаан тасраагүй тул шатахууныг ашиглаагүй байна. Бараа материалын тайлангаар тус шатахууныг зарцуулснаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6-д "Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас худалдан авсан 140.0 мянган төгрөгийн шатахууныг Хөлөнбуйр сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөх, биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 23-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч Ц.Амгаланзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

С.ТӨМӨРХУЯГ



2125040664

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN